



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрдэнэт Үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны ГЁ-111-12/760, ГЁ-111-12/2391 дугаар албан бичгээр ирүүлсэн актлах хөрөнгийг газар дээр нь үзлэг хийж, дүгнэлт гаргах, авлага суутган тооцох асуудлыг судлан санал бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ахлагч: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл

Гишүүд: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн Б.Сүнжидмаа

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн Т.Мөнхбаяр

2. Албан томилолтын зардлын төсвийг нэгдүгээр хавсралтад заасны дагуу холбогдох эх үүсвэрээс гаргаж зарцуулахыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

4. Удирдамжийн дагуу үзлэг шалгалтыг 2023 оны 5 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн ажлын 5 хоногт багтаан хийж гүйцэтгэн, тайланг танилцуулахыг Ажлын хэсэг (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ



ТӨБЗГ тушаал-/2023

137003143

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 05 дугаар сарын 01 өдрийн  
А/32 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



### **АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ**

“Эрдэнэт Үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны ГЁ-111-12/760, ГЁ-111-12/2391 дугаар албан бичгээр ирүүлсэн актлах хөрөнгийг газар дээр нь үзлэг хийж, дүгнэлт гаргах, авлага суутган тооцох асуудлыг судлан санал бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсэг ажиллаж дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.


1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгө актлах хөрөнгийн бодит байдалд үзлэг хийж фото зураг, видео бичлэг хийх,

2. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын “Стандарт металлз лимитед” ХХК-д холбогдох татварын нөхөх төлбөр болох 4,055,410,400.00 (дөрвөн тэрбум тавин таван сая дөрвөн зуун арван мянга дөрвөн зуун) төгрөгийн авлагын асуудлыг шийдвэрлэхэд материалын бүрдлийг хангуулах,

3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжүүлэхээр “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газраас татсан автомашиныг дуудлага худалдаагаар худалдах Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 141 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхэд зөвлөмж, чиглэл өгөх,

4. Удирдамжийн дагуу ажиллаж холбогдох санал, дүгнэлтийг бэлтгэн танилцуулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох шийдвэр гаргуулна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын  
 2023 оны 05 сарын 01-ны өдрийн Дугаар тушаалын  
 Нэгдүгээр хавсралт



ОРОН НУТАГТ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ЗАРДЛЫН ТӨСӨВ

(төгрөгөөр)

Д/д	Аймгийн нэр	Ажлын хэсэг		Ажиллах хүний тоо	Ажиллах хоног /календарь/	Томилолтын зардал /хоол, унаа/	Замын зардал /вагон/	Нийт зардал
		Нэр	Албан тушаал					
1	Орхон	Д.Нарангэрэл Б.Сүнжидмаа Т.Мөнхбаяр	ТӨБАХ-ийн дарга, мэргэжилтэн	3	2	852,000.00	187,200.00	1,039,200.00
	<b>ДҮН</b>				<b>6</b>	<b>852,000.00</b>	<b>187,200.00</b>	<b>1,039,200.00</b>